

Living the Lotus

12
2022

VOL. 207

Buddhism in Everyday Life



Үүсгэн байгуулагчийн бодрол

Дарматай нэгэн бүхэл болох

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганума Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулъя гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

Living the Lotus
Vol. 207 (2022.12)

Ахлах редактор: Акагава Кэйичи
Орчуулсан: Ж.Гэрэлтуяа, Оюу-Эрдэнэ
Эхийг хянасан: Монголын РКК
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Sugunami-ku, Tokyo 166-8537 Japan
TEL: +81-3-5341-1124
FAX: +81-3-5341-1224
Email: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Бурхан ямагт бидний дэргэд ном айлдаж байдаг боловч тэр сургаал номыг нь чин сэтгэлээсээ хүсэмжлэх сэтгэл байхгүй л бол Бурхан ч харагдахгүй, сургаал нь ч сонсогдохгүй. Тиймээс бидний хийх хамгийн эхний алхам бол юуны түрүүнд Лянхуа судрыг сайтар унших явдал юм. Уншихдаа зүгээр нэг унших биш, үг өгүүлбэр бүрийг нь “Бурхан надад хандан айлдаж байна” хэмээн хүлээн авч, сэтгэл зүрхэндээ сийлэн тогтоож унших хэрэгтэй.

Судрыг ингэж уншсанаар Бурхан бидний төлөө ямар их санаа тавьдаг болохыг ойлгоно. Лянхуа судрын ач буяныг алган дээр дэлгэсэн юм шиг тов тод дэлгэрэнгүй тайлбарлаж өгөх Бурханы нигүүлсэхүй зүрх сэтгэлд нэвт шингэж, өөрийн эрхгүй сэтгэл хөдлөн догдолдог. Энэ бол Лянхуа судрыг хэрэгжүүлэхийн ач холбогдол юм.

Ийнхүү Бурханы сургаалыг өдөр бүр ажил амьдралдаа нэгийг нь ч болтугай хэрэгжүүлж, хэн нэгэнтэй харилцахдаа сургаалд заасны дагуу сэтгэлээ өөрчлөхийн төлөө хичээгээд байх юм бол нэг л мэдэхэд цоо шинэ хүн болсон байх болно. Дарматай аажмаар нэгэн бүхэл болж, бие сэтгэл гэрэлтэн гийнэ.

«Үүсгэн байгуулагчийн үг» 11, X144-145

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг туулцаагай гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.

Хотол олноороо аз жаргалтай болохын төлөө (Зургаан барамид)

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч
Нивано Ничикоо



Нисваанисаа боди сэтгэл болгон хувиргах нь

Хүмүүс бидэнд хэрэгцээнээсээ илүүг хүсэмжлэх шуналын сэтгэл, хувиа хичээсэн бодлоор бусдад уурлаж, үзэн ядах сэтгэл, түүнчлэн мөнхийн өөрчлөгддөггүй зүйл гэж ганц ч байхгүй ба бүх зүйлс шүтэн барилдлагаар оршин тогтнодог гэсэн бүх зүйлд хамаатай хуулийг мартсан аминч үзлээс үүсэлтэй шунал, уур хилэнгээ зөв гэж бодох сэтгэл гэх мэт олон янзын “нисваанис” байдаг. Эдгээр нь бүгд зовлонгийн үр гэж хэлж болохоор зүйлс юм.

Гэхдээ Лянхуа судраас авахуулаад бурхны шашны их хөлгөний урсгалын сургаалуудад ийм нисваанис байсан ч гэсэн эгэл жирийн ямар ч хүн зовлон бэрхшээлээс ангижрах боломжтой гэж сургадаг. Хүнд нисваанис байдаг учраас л бид хүнлэг мөн чанараа сайжруулахыг зорьж, амьдрал үхлийн талаарх эргэлзээ төөрөгдөл байдаг болохоор л туйлын үнэнийг эрэлхийлдэг. Тиймээс нисваанис байсан ч гэсэн зовлонгүй амьдарч болох ба бүр нисваанисаа илүү сайхан амьдрах билиг ухаан болгон хувиргах боломжтой. Энэ нь л чухамдаа хүн бүхэн жинхэнэ аз жаргалыг олох арга зам бөгөөд бид үүнийг сургадаг сургаалтай учирсан билээ.

Энэ жил та бүхэнтэй хамт суралцсан “Зургаан барамид”-ын сургаал бол түүний нэг болно. Эргээд дүгнэхэд тус сургаалын хэсэг болгон нь шунал, уур хилэн, баригдмал сэтгэл зэрэг нисваанистай салшгүй холбоотой байсан ба аминч үзлээ бодисадвагийн үйл болгон хувиргах түлхүүр тэнд үргэлж нуугдаж байсан. Яг одоо бид олон зүйлийн ачаар амьдарч байгаа тул бие сэтгэлээ уур уцаар, баригдмал сэтгэлд биш бодисадвагийн үйлд зориулах чухал. Үүнийг хэрэгжүүлэх түлхүүр нь “бусдын төлөө” гэсэн сэтгэл юм.

Тэгвэл бид өдөр бүр энэ “бусдын төлөө” гэдэг үгийг хэлж, залбирдаг шүү дээ. Та бүхэн үүнийгээ анзаарсан уу?

“Бүх амьтан лугаа” гэсэн сэтгэлээр

Бид судар уншихдаа “Энэ буяныг бүгд бээр хураах болтугай, бүх амьтан лугаа бурханы замд орж гэтлэх болтугай” хэмээн дууддаг. Мөн Бурхан, ном, хувраг гэсэн гурван эрдэнэд мөргөхдөө “үнэхээр бүгд амьтны хамт” гэж өглөө, оройд тангарагладаг. Бид ийнхүү үргэлж “Бүх хүмүүстэй хамтдаа аз жаргалтай болъё” хэмээн залбирч, тангараглан алга хавсран бурхандаа мөргөдөг шүү дээ.

Буддизмын Жоодо-шиншү урсгалын Канэко Даиэй (1881-1976) багштан энэ “бүх амьтан лугаа” хэмээх үгийг тайлбарлахдаа “өөрийнхөө төлөө хийж буй ямар ч бурханы үйл бүх амьтны төлөө болдог учраас бусдын төлөөх үйл бүхэн өөрийн зам мөр болдог. Энэ нь л чухамдаа бодисадвагийн үйл юм” гэж хэлсэн байдаг. Мөн түүнчлэн “бүх амьтан лугаа” гэсэн сэтгэлтэй байх юм бол үзэж харсан болгон зөв ном болон хувирч, ойлгож ухаарсан бүхэн зам мөрийг эрэлхийлэх сэтгэлд эрч хүч өгдөг гэж хэлээд, бүх амьтан лугаа амьдрах бодисадва хүний амьдрал өөрөө зам мөрийн газар хэмээн сургажээ. Зургаан барамидын жинхэнэ мөн чанар үүнд л оршдог болов уу.

Тэгвэл “бүх амьтан лугаа” хэмээн залбирах та яг одоо дэргэдэх хүнийхээ төлөө юу хийж чадах вэ? Зурагт, интернэтээр алс холын улс орны нөхцөл байдлыг харах үед “бүх амьтан лугаа” гэж залбирах таны сэтгэлд юу бодогддог вэ?

Ганц хүний хүчээр юу ч хийх боломжгүй байлаа ч, хүн бүр хэрхэн амьдрахаа эргэцүүлэн, эргэн тойрондоо хийж чадах зүйлээ хийе гэсэн чин сэтгэл нь Бурханы агуу үйлчлэлийн нэг хэсэг болдог гэдэгт би итгэдэг. Жишээлбэл өвчний улмаас хэн нэгэн хүнд ямар нэгэн зүйл хийж өгч чадахгүй байлаа ч гэсэн “бүх амьтан лугаа” хэмээн бусдын төлөө залбирч бол чадна. Энэ нь өөр шиг нь өвчнөөр шаналж байгаа хүмүүсийг хурдан эдгээсэй гэсэн залбирал болж, хурдан эрүүл саруул болоод бусдад урам зориг өгөх юмсан гэсэн эрч хүчийг өгч, өөрийн сэтгэлийн зовлон шаналалыг үлдэн хөөдөг. Түүнчлэн өвчнөөр шаналж үзээгүй хүнд байхгүй өвчин зовлонг хүлээж авах сэтгэлийн хатыг суулгаж, амар амгаланг мэдрүүлдэг.

Эцэст нь он дуусах агшинд нисваанисын тоогоор цохих хийдийн хонхны дууг сонсонгоо энэ жил хүнд хэцүү жил байсан ч гэсэн Кобаяши Исса (1763-1828) гуайн “Он дуусах мөчийн одот тэнгэр юутай үзэсгэлэнтэй вэ” хэмээх шүлгийг санаж, өөдрөг сайхан шинэ оноо угтаарай хэмээн хүсэж байна.

“Косей” сэтгүүл, 12-р сарын дугаар

Рисшо Косей Кай Нийгэмлэг

(Зурагт ном)

Шагжамүни бурхан багшийн амьдрал ба сургаал

Амар амгалан сэтгэл

“Бүх юмс хувирч өөрчлөгддөг”, “Юу ч ганцаар оршин тогтнодоггүй” хэмээх үнэнийг сайтар ойлгож, зөв хэрэгжүүлж чадах юм бол өдөр бүр амар амгалан байх болно гэж сургадаг сургаал бол “Нирваан нь туйлын амгалан” хэмээх сургаал юм.

Ямар нэг асуудалтай тулгарах үедээ “аливаа зүйлс хувирч өөрчлөгдөх нь ойлгомжтой, зөв тал руу нь өөрчлөхийн төлөө хичээе”, “ганцхан өөрт биш бүх хүмүүст ашиг тустай байх арга замыг олъё” гэсэн сэтгэлээр хандаж амьдрах чухал. Ийм хандлагатай байх аваас хэрүүл тэмцэлгүй, сэтгэл санаа тайван тогтвортой байж, хүмүүстэй эв эетэй сайхан амьдарч чадна.



Бяцхан мэдлэг

“Нирваан” гэдэг нь “нисваанисын гал унтарч, сэтгэлийн амар амгаланг олох” гэсэн утгатай ба бурхны сургаалын зорилго үүнд оршдог. Үүнээс улбаалан “амь насны гал унтрах” гэсэн утгыг ч илэрхийлэх болж, “нас нөгчих”, “нирваанд орох” гэсэн утгыг ч бас давхар илэрхийлэх болжээ.

Хувьдаа ашиглахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй олшруулж, мэдээллийн хэрэгсэл дээр байршуулахыг хориглоно.



Зовлонгоос ангижрах арга зам




Хүний зовлонгийн шалтгаан, түүнээс ангижрах арга замыг заадаг сургаал бол “Хутагтын дөрвөн үнэн” ба зовлон үнэн, зовлонгийн шалтгаан үнэн, зовлонгоос гэтлэх үнэн, зовлонгоос гэтлэх арга зам үнэн хэмээн сургадаг.

Амьдралын дөрвөн зовлон, найман зовлон гэж байдаг ба тэдгээрийг сайтар ажиглаж, нүүр тулах чухал (зовлон үнэн). Тэр зовлонгийн шалтгаан нь шунал хүсэл байдаг (зовлонгийн шалтгаан үнэн). Шунал хүслээсээ бүрэн ангижирснаар зовлон үүсэхгүй болдог (зовлонг гэтлэх үнэн). Зовлонгүй болохын тулд Найман зөв зам мөрийн сургаалыг хэрэгжүүлэх хэрэгтэй (зовлонг гэтлэх арга зам үнэн). Хутагтын дөрвөн үнэн сургаал нь ийнхүү сургадаг. Дараагийн удаа “Найман зөв зам” сургаалаас суралцах болно.



Бяцхан мэдлэг

Зовлон үнэн гэдэг нь зовлонгоо сайтар ухаарахыг сургадаг. Энэ сургаалыг зовлон үнэн, зовлонгийн шалтгаан үнэн, зовлонгоос гэтлэх үнэн, зовлонгоос гэтлэх арга зам үнэн гэсэн дарааллаар сурах боловч хэрэгжүүлэхдээ зовлон үнэн, зовлонгийн шалтгаан үнэн, зовлонг гэтлэх арга зам үнэн, зовлонгоос гэтлэх үнэн гэсэн дарааллаар хэрэгжүүлдэг.



Олон улсын хэлтсийн даргын булан

Яг одоо л “бусдын төлөө үйл”-ийг хэрэгжүүлэх үе

Дүн өвлийн улирал ирлээ. Жил болгон энэ үе ирэхээр “Он жил биднийг үл хүлээнэ” хэмээх зүйр үг санаанд ордог юм. “Он жил хүмүүс биднээс үл хамааран хоромхон зуур ч зогсолтгүй урсан өнгөрдөг” гэсэн утгатай. Энэхүү нийтлэлийг уншин буй та бүхэн 12 сартай золгож буй энэ мөчид энэ жилийг хэрхэн дүгнэж байна вэ?

Корона вирусын цар тахал 3 жил үргэлжилж, дуусах үгүй нь мэдэгдэхгүй хэвээр. 2 сард Орос Украин руу цэргийн дайралт хийн, одоо ч дайны гал ассаар байна. Улс орнуудад юмны үнэ өсөж, ард иргэдийн амьдралд их бага хэмжээгээр нөлөөлж байна. Бурхны сургаалд заасан билиг билгүүн ба нигүүлсэхүй дэлхий нийгмийн эдгээр олон асуудлыг шийдэхэд ямар гарц гаргалгааг зааж өгөх бол?

Нивано ерөнхийлөгч энэ сарын айлдвартаа “Хамаг амьтан лугаа” гэсэн сэтгэлээр үйлдэх зургаан барамидын сургаалыг хэрэгжүүлэх, улам олон бодисадва нарыг төрүүлэх чухал хэмээн айлдсан. Энэ нь л чухамдаа дэлхий нийгэмд хувь нэмэр оруулах бидний үүрэг, гарц гаргалгаа гэж бодогдож байна. Яг одоо л “бусдын төлөө үйл”-ийг хэрэгжүүлэх үе гэж та бүхэн ч гэсэн бодож байгаа гэдэгт итгэж байна.


Акагава Кэйичи



We welcome comments on our newsletter Living the Lotus: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp



Rissho Kosei-kai: A Global Buddhist Movement



Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, USA
TEL: 1-808-455-3212 FAX: 1-808-455-4633
Email: sangha@rkhawaii.org URL: <https://rkhawaii.org>

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1809 Nani Street, Wailuku, HI 96793, USA
TEL: 1-808-242-6175 FAX: 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, USA
TEL: 1-808-325-0015 FAX: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, USA
TEL: 1-323-269-4741 FAX: 1-323-269-4567
Email: info@rk-la.org URL: <https://www.rk-la.org>

Please contact Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

- Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado**
- Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas**

Rissho Kosei-kai of San Francisco

(Address) 1031 Valencia Way, Pacifica, CA 94044, USA
(Mail) POBox 778, Pacifica, CA 94044, USA
TEL: 1-650-359-6951 Email: lotusbuddhist@gmail.com
URL: <https://sf-buddhism.org>

Please contact Rissho Kosei-kai of San Francisco

Rissho Kosei-kai of Sacramento

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, USA
TEL: 1-212-867-5677 Email: rkny39@gmail.com URL: <https://rk-ny.org>

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, USA
TEL: 1-773-842-5654
Email: rkchicago@rkchi.org URL: <http://rkchi.org>

Rissho Kosei-kai of Fort Myers

Email: rkftmyersbuddhism@gmail.com URL: <https://rkftmyersbuddhism.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

(Address) 2745 N.W. 40th St., Oklahoma City, OK 73112, USA
(Mail) POBox 57138, Oklahoma City, OK 73157, USA
TEL: 1-405-943-5030 FAX: 1-405-943-5303
Email: dharmacenter@rkok-dharmacenter.org
URL: <https://rkok-dharmacenter.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Denver

1255 Galapago St. #809, Denver, CO 80204, USA
TEL: 1-303-446-0792

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

617 Kling Drive, Dayton, OH 45419, USA
URL: <http://www.rkina-dayton.com>

The Buddhist Center Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First St., Suite #1, Los Angeles, CA 90033, USA
TEL: 1-323-262-4430 FAX: 1-323-269-4567
Email: info@rkina.org
URL: <https://www.buddhistcenter-rkina.org>

Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

(Address) 6083 Babcock Road, San Antonio, TX 78240, USA
(Mail) POBox 692148, San Antonio, TX 78249, USA
TEL: 1-210-558-4430 FAX: 1-210-696-7745
Email: dharmasa@rksabuddhistcenter.org
URL: <https://rksabuddhistcenter.org>

Rissho Kosei-kai of Seattle

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, USA
TEL: 1-253-945-0024 Email: rkseattlewashington@gmail.com
URL: <https://www.buddhistlearningcenter.org>

Rissho Kosei-kai of Vancouver

Please contact RKINA

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP, CEP 04116-060, Brasil
TEL: 55-11-5549-4446, 55-11-5573-8377
Email: risho@rkk.org.br URL: <http://rkk.org.br>
Facebook: <https://www.facebook.com/rishokosseikaidobrasil>
Instagram: <https://www.instagram.com/rkkbrasil>

在家佛教韓國立正佼成會 Korean Rissho Kosei-kai
〒 04420 大韓民國 SEOUL 特別市龍山區漢南大路 8 路 6-3
6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea
TEL: 82-2-796-5571 FAX: 82-2-796-1696

在家佛教韓國立正佼成會釜山支部

Korean Rissho Kosei-kai of Busan
〒 48460 大韓民國釜山廣域市南區水營路 174, 3F
3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea
TEL: 82-51-643-5571 FAX: 82-51-643-5572

社團法人 在家佛教立正佼成會 Rissho Kosei-kai of Taipei
台灣台北市中正區衡陽路 10 號富群資訊大廈 4 樓
4F, No. 10, Hengyang Road, Jhongheng District, Taipei City 100, Taiwan
TEL: 886-2-2381-1632, 886-2-2381-1633 FAX: 886-2-2331-3433

台南市在家佛教立正佼成會 Rissho Kosei-kai of Tainan
台灣台南市東區崇明 23 街 45 號
No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701, Taiwan
TEL: 886-6-289-1478 FAX: 886-6-289-1488
Email: koseikaitainan@gmail.com

Rissho Kosei-kai South Asia Division

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8141

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsikhel, Sanepa-1, Lalitpur, Kathmandu, Nepal

Rissho Kosei-kai Society of Kolkata

89 Srirampur Road (VIP), Garia, Kolkata 700084, India

Rissho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Bodhgaya

Ambedkar Nagar, West Police Line Road, Rampur, Gaya-823001,
Bihar, India

Rissho Kosei-kai of Patna

Please contact Rissho Kosei-kai Society of Kolkata

Rissho Kosei-kai of Delhi

77 Basement D.D.A. Site No. 1, New Rajinder Nagar,
New Delhi 110060, India

Rissho Kosei-kai of Singapore

Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai of Phnom Penh

W.C. 73, Toul Sampaov Village, Sangkat Toul Sangke, Khan Reouseykeo,
Phnom Penh, Cambodia

Rissho Kosei-kai International of South Asia (RKISA)

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8141

Rissho Kosei-kai of Bangkok

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8216 Email: info.thairissho@gmail.com

Rissho Kosei Dhamma Foundation

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka
TEL: 94-11-2982406 FAX: 94-11-2982405

Rissho Kosei-kai of Polonnaruwa

Please contact Rissho Kosei Dhamma Foundation

Rissho Kosei-kai Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
TEL: 880-2-41360470

Rissho Kosei-kai Mayani

Mayani Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Damdama

Damdama Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Satbaria

Village: Satbaria Bepari Para, Chandanaih, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Chendhirpuni

Village: Chendhirpuni, P.O.: Adhunogar, P.S.: Lohagara, Chittagong,
Bangladesh

Rissho Kosei-kai Raozan

Dakkhin Para, Ramzan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Laksham

Village: Dhupchor, Laksham, Comilla, Bangladesh

Rissho Kosei-kai Dhaka North

Bashundhara R/A, Dhaka, Bangladesh

Rissho Kosei-kai Cox's Bazar

Ume Burmize Market, Tekpara, Sadar, Cox's Bazar, Bangladesh

Please contact Rissho Kosei-kai Bangladesh

Rissho Kosei-kai Patiya

Rissho Kosei-kai Ramu

Rissho Kosei-kai Aburkhil

Buddiyskiy khram "Lotos"

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk 693005, Russia
TEL: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point, Hong Kong, China

Rissho Kosei-kai Friends in Shanghai

Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai of Ulaanbaatar

(Address) 15F Express Tower, Peace avenue, khoro-1, Chingeltei district,
Ulaanbaatar 15160, Mongolia

(Mail) POBox 1364, Ulaanbaatar-15160, Mongolia

TEL: 976-70006960 Email: rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Erdenet

Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai di Roma

Via Torino, 29, 00184 Roma, Italia

TEL/FAX: 39-06-48913949 Email: roma@rk-euro.org

Please contact Rissho Kosei-kai di Roma

Rissho Kosei-kai di Venezia

Rissho Kosei-kai of Paris

Rissho Kosei-kai of the UK

29 Ashbourne Road, London W5 3ED, UK

TEL: 44-20-8933-3247 Email: info@rkuk.org URL: <https://www.rkuk.org>

Facebook: <https://www.facebook.com/rkuk.official>

Twitter: https://twitter.com/rkuk_official

Instagram: https://www.instagram.com/rkuk_official

YouTube: https://www.youtube.com/c/rkuk_official

Rissho Kosei-kai International Buddhist Congregation (IBC)

〒 166-8537 東京都杉並区和田 2-7-1 普門メディアセンター 3F

Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537, Japan

TEL: 03-5341-1230 FAX: 03-5341-1224 URL: <https://www.ibt-rk.org>